

ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМД ӨГӨХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН САНАЛ, ШҮҮМЖ

Танилцуулга

Нээлттэй Нийгэм Форум, Төлсөн авсанаа нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвслээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 ба 62.3.4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор шинээр боловсруулж буй газрын тосны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмуудын төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Түүнчлэн ННФ нь Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг сайжруулах чиглэлээр холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан болно.

Ийнхүү хэлэлцүүлгийн явцад дээрх дүрмийн талаар иргэний нийгмийн байгууллагуудаас болон зөвлөх инженер, доктор, дэд профессор К.Хавалболотаас өгсөн санал, шүүмжийг нэгтгэн “Хуулийн шүүмж”-ийн энэ дугаарт эмхэтгэн гаргав.

Нэг. Тус дүрэм нь олон улсны стандарт, монгол улсын хууль тогтоомж, мөрдөгдөж буй стандарттай нийцсэн эсэх талаар:

- Дүрмийн төслийн 1 ба 2 дугаар зүйлд тухайн дүрмийн нийтлэг зүйл, үйлчлэх хүрээг зааж өгсөн бол бусад бүлэг нь эрэл, хайгуулын аюулгүй ажиллагааны шаардлага, ажилтны хөдөлмөр зохион байгуулалт, бэлтгэл ажил, аттестатчлалд тавигдах аюулгүй ажиллагааны болон ашиглалт, олборлолтын аюулгүй ажиллагааны шаардлага гэх мэт дээр дурдсан бүлгүүд бүхий газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны үе шат бүрд мөрдөх аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрмийг тусгасан бүтэцтэй бичигджээ.
- Дүрмийг Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа, MNS OHSAS 18001, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, Геологи хайгуулын ажилд мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм (1985 оны) болон ОХУ, Казактсан Улсад мөрдөж байгаа нефт ба хийн үйлдвэрийн аюулгүй байдалд тавигдах шаардлага, норм ба дүрмийг ашиглан боловсруулжээ.

- Уг дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандарттай нийцсэн байх ёстой. Мөн олон улсын стандарт, холбогдох дүрмийг харьцуулан судалж тусгаж өгөх нь чухал.¹ Тухайлбал, Petroleum and gas (production and safety) regulation 2004 (2016 онд зарим өөрчлөлт орсон), Managing risks of plant in the workplace code of practice (газрын тос, хийн үйлдвэрийн эрсдэлийн удирдлагатай холбоотой заавар), Competency standard for petroleum and gas well drilling and well servicing (2014 газрын тос, хийн үйлдвэрийн) өрөмдлөг, цооногийн засвар үйлчилгээтэй холбоотой стандарт), Code of practice for the construction and abandonment of petroleum wells and associated bores in Queensland, Code of practice for leak management, detection and reporting for petroleum production facilities болон БНХАУ, АНУ зэрэг улс оронд мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг судлан үзэх шаардлагатай гэж үзэж байна.
- Дүрмийг газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хайгуулын ажлаас цооногийн өрөмдлөгөөс засвар үйлчилгээ хүртэлх бүх үйл ажиллагааг хамруулан бичсэн бөгөөд зарим заалт утга санаа, агуулгын хувьд давхардсан нь харагдаж байна. Зүйл болгонд галын аюулгүй ажиллагааг хангах заалтууд байгааг Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм журамтай нийцүүлэн нэгдсэн нэг бүлэг болгох нь зүйтэй.
- Орчин үед аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг ханган ажиллах суурь үндэс болсон байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн систем, хяналт, эрсдэлийн үнэлгээ, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл болон ажилтны амрах байрны эрүүл ахуйн стандарт, хяналт шалгалт зэрэг нь хуульчлагдсан учир эдгээр асуудлыг эрэл, хайгуулаас олборлолт, ашиглалт хүртэлх бүх шатыг хамруулан тухайн салбарын хувьд хэрхэн авч үзэх талаар заалтуудыг тусгаж өгөх шаардлагатай байна.

Хоёр. Дүрмийн төслийн бүтэц, агуулгыг сайжруулах, олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, мөрдөгдөж буй стандартад нийцүүлэхэд чиглэсэн санал

- Дүрмийн зорилго, эрх зүй, холбогдох нэр томъёоны тодорхойлолт, удирдлага зохион байгуулалт, тус салбарт ажиллах ажилтан, ажилчдад тавигдах шаардлага, сургалт зааварчилгаа, ажлын байрны зохион байгуулалт, ХАБЭА-н хяналт, менежментийн систем, эрсдэлийн үнэлгээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ажлын болон амрах байрны эрүүл ахуй, бичил цаг уур, агааржуулалт, дуу шуугиан, гэрэлтүүлэг, хувийн хамгаалах хэрэгсэл зэрэг газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны үе шат бүрд байх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйтай холбогдох нийтлэг шаардлагуудыг тусган өгч Нэгдүгээр бүлэг: “Нийтлэг шаардлага” гарчгийн доор нэгтгэх авч үзэх нь зүйтэй санагдлаа.
- Ингэхдээ одоо байгаа дүрмийн төслийн нэг, хоёрдугаар зүйлийг нэгтгэн Дүрмийн зорилго, үйлчлэх хүрээ хэмээн нэрлэж 1.1-р дэд бүлэг болгон авч үзэх нь зохистой.
- Дүрмийн төслийн хавсралт 2-т товчилсон үг, нэр томъёог оруулсан боловч энд зөвхөн товчилсон үгсийн тайлбарыг оруулжээ. Иймд 1.2-р дэд бүлэгт тухайн дүрэмд хэрэглэж буй мэргэжлийн үг хэллэг, ХАБЭА-тай холбоотой нэр

¹ Шаардлагатай бол нэр дурдсан олон улсын стандартуудыг цахим хэлбэрээр гаргаж өгөх боломжтой.

томьёонуудыг тайлбарлаж өгөх нь тухайн дүрмийг эхлэн суралцаж, цаашид хэрэгжүүлэх этгээдүүдэд илүү ойлгомжтой, логик дараалалтай болохоор байна.

- Ажилтнуудын хөдөлмөр зохион байгуулалт, удирдлага, мэргэжил, мэргэшлийн ур чадварын аттестатчлал, сургалт зааварчилгаа нь зөвхөн газрын тос, уламжлалт бус газрын тосны олборлолт, ашиглалтын явцад бус эрэл хайгуулын шатанд хүртэл яригдахын зэрэгцээ тухайн салбарын хөдөлмөрийн харилцаанд орж байгаа бүх этгээдэд хүчинтэй тул эдгээр асуудлыг тусган 1.3-р дэд бүлгийг “Удирдлага зохион байгуулалт, ажилтан, албан хаагчдад тавигдах шаардлага, сургалт зааварчилгаа, аттестатчлал” гэсэн агуулгатайгаар бичих саналтай байна. Ингэхдээ дүрмийн төслийн 17-р зүйлд заасан “Хариуцлага”-ыг нэгтгэн тусгах нь зүйтэй. Гэхдээ зөрчилд тооцох хариуцлагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Галын аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хуулиуд заасны дагуу оногдуулах үүднээс дээрх хуулиудыг иш татах байдлаар зохицуулах нь зүйтэй.
- Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н хяналт, менежментийн систем, эрсдэлийн үнэлгээг салбарын онцлогтой уялдуулан Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай хууль, MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа, MNS OHSAS 18001, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон бусад холбогдох дүрэм журамтай нийцүүлэн хэрхэн хангах, гүйцэтгэх асуудлыг 1.4-р дэд бүлэг тусгах нь зохистой байна.
- Дүрмийн төслийн 15-р зүйлд ажлын байрны зохион байгуулалт, ажилтны хувийн хамгаалах хэрэгслийн аюулгүй ажиллагааны шаардлага гэж байгаа бөгөөд энэ нь нийт ажилтан, ажил олгогч талын бүгдэд хамаатай тул нийтлэг байдлаар бичиж 1.5-р дэд бүлэг болгох нь зүйтэй.
- Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны өөр хоорондоо ялгаатай процесс бүрт тоног төхөөрөмжүүд ашиглагдах бөгөөд тэдгээрийн аюулгүй ажиллагаатай холбоотой нийтлэг зүйлсийг эмхэтгэн нэгтгэж “Тоног төхөөрөмжийн ашиглалт” агуулгатайгаар 1.6-р дэд бүлэг болговол дүрмийн бусад хэсэгт давхардал үүсэхгүй байх талтай.
- Дүрмийн 1.7-р дэд бүлэгт Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм журамд нийцүүлэн салбарын онцлог байдлыг хамруулсан Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг тусгаж өгөх нь зүйтэй. Дүрмийн төсөлд галын аюултай холбоотой заалтууд бүлгүүдэд байгаа боловч нэгдсэн дэд бүлэг хэлбэрээр бичигдэж 1-р бүлэгт тусгагдах нь оновчтой.
- Эрэл хайгуулын үе шатаас олборлолт, ашиглалтын бүхий л үе шат дахь онцлогуудыг нарийн тусгаж, ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, бичил цаг уур (бичил цаг уур, агааржуулалт, дуу шуугиан, гэрэлтүүлэг)-ын үнэлгээтэй холбоотой асуудлыг багтаан 1.8-р дэд бүлгийг “Эрүүл ахуй, байгаль орчны хамгаалал” агуулгатайгаар тусад нь оруулах зүйтэй.
- Хоёрдугаар бүлгийг “Цахилгаан хангамж, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа” гэж нэрлэн, 2.1-р дэд бүлэгт “Нийтлэг шаардлага” агуулгын дор тухайн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг шаардлагуудыг нэгтгэн, бүх бүлэгт ерөнхий байдлаар давхцах нийтлэг заалтуудыг нэгдүгээр бүлгийн харгалзах дэд бүлгүүд рүү оруулж өгөх. Ингэхдээ “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”, “Хэрэглэгчдийн цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглах

үеийн техникийн аюулгүйн дүрэм” болон бусад холбогдох дүрэм, заавар, норм, стандартын шаардлагуудыг хангасан байх ёстой.

- Барилга байгууламж нь “Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар”, цахилгаан байгууламжийн тусгаарлага нь “Цахилгаан байгууламжийн дүрэм”, угсралтын ажил нь “Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм” болон “Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм”, хамгаалах газардуулгын систем нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа, Хамгаалах газардуулга тэглэлт”, цахилгаан хангамжийн зураг төсөл нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.
- Цахилгаан тоног төхөөрөмжид болон цахилгааны нөлөөллөөс болж гарсан осол, гэмтлийг Засгийн газрын тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу судална.
- Өндөрт ажил гүйцэтгэхдээ “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”, “Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм” болон бусад холбогдох дүрэм, заавар, норм, стандартын шаардлагуудыг хангасан байна.
- Гуравдугаар бүлгийг “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын аюулгүй ажиллагаа” гэж нэрлэн 3.1-р дэд бүлэгт “Нийтлэг шаардлага” агуулгын дор тухайн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг шаардлагуудыг нэгтгэн газрын тосны олборлолт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай давхцах заалтуудыг нэгдүгээр бүлгийн харгалзах дэд бүлгүүд рүү оруулж өгөх. Тухайлбал, “3.4, 3.5, 3.6, 3.7 заалтууд нь хувийн хамгаалах хэрэгсэл, зааварчилгаатай холбоотой байгаа бөгөөд 3.7-д ажилчид хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээ бүрэн ашиглана гэсэн заалт” нь 1-р бүлэгт хөдөлмөр хамгаалал гэж буруу нэр томъёогоор бичигдсэнээс гадна бүх ажилчид хувцас хэрэглэлээ бүрэн ашиглах ёстой тул 1-р бүлэгт орох ёстой.
- Дөрөвдүгээр бүлгийг газрын тосны ашиглалт, олборлолтын аюулгүй ажиллагаа (Дүрмийн төслийн 5-р зүйл), тавдугаар бүлгийг Газрын тос олборлох, хурааж цуглуулах, бэлтгэх үеийн аюулгүй ажиллагаа (Дүрмийн төслийн 6-р зүйл), зургаадугаар бүлгийг Цооног угсралтын үеийн аюулгүй ажиллагаа (Дүрмийн төслийн 8, 9, 11, 12-р зүйл), долоодугаар бүлгийг Цооногийн туршилтын үеийн аюулгүй ажиллагаа (Дүрмийн төслийн 10-р зүйл), наймдугаар бүлгийг Газрын тосны цооногт хийгдэх каротажийн аюулгүй ажиллагаа (Дүрмийн төслийн 13-р зүйл), есдүгээр бүлгийг Цооногийн засвар шинэчлэлтийн үеийн аюулгүй ажиллагаа (Дүрмийн төслийн 14-р зүйл) агуулгатайгаар оруулж өгөх саналтай байна.
- Дээрх бүлгүүд дэх ерөнхий нийтлэг заалтуудыг нэгдүгээр бүлгийн харгалзах дэд бүлэг рүү, бүлэг доторх нийтлэг зүйлсийг тухайн бүлгийн *.1 –р дэд бүлэг болгож өгөх нь зүйтэй (* - тухайн бүлгийн дугаар).

Дугаарыг эрхэлсэн: Д.ЭРДЭНЭЧИМЭГ

ННФ-ын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

